Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Дотоод хяналт хариуцсан нэгж ажилладаггүй бөгөөд энэ талаар ямар нэгэн тодорхой хийж гүйцэтгэсэн ажил байхгүй байгаагаас шалтгаалан үр нөлөөгүй гэж үзсэн болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,420,197.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 34,201.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 380,369.2 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурч, материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| **Б** | **1** | **2** | **3=2-1** |
| Авлага | 52,175.0 | 22,210.0 | (29,965.0) |
| Бараа материал | 313,270.4 | 251,550.7 | (61,719.7) |
| Үндсэн хөрөнгө | 6,956,592.2 | 6,690,117.8 | (266,474.5) |
| **Нийт хөрөнгө** | **7,322,037.7** | **6,963,878.5** | **(358,159.2)** |
| Өр төлбөр | - | 20,880.0 | 20,880.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,939,702.7 | 2,939,702.7 | - |
| Хуримтлагдсан үр дүн | (1,072,898.6) | (1,451,937.7) | (379,039.2) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,455,233.5 | 5,455,233.5 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **7,322,037.7** | **6,963,878.5** | **(358,159.2)** |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын данс нь 29,965.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд оюутны мэргэшүүлэх сургалт, дадлагын төлбөрийн болон бусад авлага 259,635.4 нэмэгдэж, 289,600.5 мянган төгрөгийн авлагыг цуглуулан ажилласнаас шалтгаалсан;
- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа материал 114,652.0 мянган төгрөг, хандиваар 2,960.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, сургалтын үйл ажиллагаанд 179,332.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 61,719.7 мянган төгрөгөөр буурсан;

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 266,474.5 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын шийдвэрээр барилга байгууламж 21,000.0 мянган төгрөг, ХНХЯ-аас 51,273.0 мянган төгрөгийн 26 ширхэг суурин компьютер, тоног төхөөрөмж, 1,941.3 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй шилжүүлэн авснаар нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардал 359,756.8 мянган төгрөгөөр буурснаас тус тус шалтгаалсан;
- Өр төлбөрийн 20,880.0 мянган төгрөг нь оюутны мэргэшүүлэх дадлагын урьдчилж орсон орлогын үлдэгдэл байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 4,343,610.8 мянган төгрөг, үүнээс урсгалт зардалд 4,343,610.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс урсгал зардлыг 1,288,558.8 мянган төгрөгөөр бууруулан 3,055,052.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг 1 удаа хийж, санхүүжилтийн эх үүсвэрийг 106,986.0 мянган төгрөгөөр бууруулж, 2,948,066.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 2,703,066.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 215,000.0 мянган төгрөгийг тус коллежийн үндсэн үйл ажиллагаанаас, 30,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,703,066.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 215,00.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанаас, 30,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,546,729.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 267,798.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 2,370.4 мянган төгрөг, нийт 2,816,899.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,816,899.1 мянган төгрөгийг зарцуулж, 155,336.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тус коллежийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 245,000.0 мянган төгрөг байсан ба 110.3 хувийн гүйцэтгэлтэй буюу 270,169.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,816,899.1 мянган төгрөг буюу 95.6 хувьтай байгаа нь үндсэн болон нэмэгдэл цалингийн зардлыг 57,362.5 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 31,623.9 мянган төгрөгөөр, хичээл, нормативт зардлыг 19,234.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Үүнээс гадна харуул хамгаалалтын зардалд 53,200.0 мянган төгрөгийг төлөвлөж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай хуулийн дагуу тендерийг зохион байгуулж, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжид 38,940.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Тайлант онд хоол, хүнсний зардалд 41,923.0 мянган төгрөгийг төсөвлөсөн ковид-19 цар тахалтай холбогдуулан оюутнуудыг дотуур байрнаас гаргаж орон нутагт буцаасантай холбоотойгоор 22,689.0 мянган төгрөгийг оюутнуудад хоолны зардлаар олгож 19,234.0 мянган төгрөгийн хэмнэлт гарсан байна.

Хүснэгт – 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээний | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| | Код | Нэр | | | | |
| 1 | 71804 | Тусгай мэргэжлийн боловсрол | 2,948,066.1 | 2,816,899.1 | 131,166.9 | 95.5 |
| 1.1 | 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,588,084.5 | 2,486,158.1 | 101,926.4 | 96.1 |
| 1.2 | 80219 | Харуул хамгаалалтын зардал | 52,200.0 | 45,340.0 | 6,860.0 | 86.9 |
| 1.3 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж,урамшуулал | 21,524.6 | 18,415.2 | 3,109.4 | 85.6 |
| 1.4 | 80813 | Хуульд заасан үндэслэлээр албан хаагчид олгох нөхөн олговор | 244,334.0 | 244,296.8 | 37.2 | 99.9 |
| 1.5 | 81806 | Дотуур байрны хүүхдийн хоол | 41,923.0 | 22,689.0 | 19,234.0 | 54.1 |
| | | Дундаж хувь | | | | 92.1 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Монгол Улсын Сангийн сайдын А/217 тоот тушаалаар 2021 оны оюутны мэргэшүүлэх хөтөлбөрийн үйл ажиллагааны давсан орлого 71,172.4 мянган төгрөг, оюутны бүртгэлийн хураамж 12,260.0 мянган төгрөг нийт 83,432.4 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтээр бүрдүүлжээ.

Үүнээс ажиллагсдын нийгмийн баталгааг хангах  зардалд 50,800.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 11,200.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн ангийн компьютер, тоног төхөөрөмжийн зардалд 9,172.4 мянган төгрөг нийт 71,172.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,260.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж нь мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалтуудыг явуулж нийтлэг үйлчилгээ, техник технологи, үйлдвэрлэлийн болон урлал дизайны зэрэг 8 салбарын 38 төрлийн мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг. 2021-2022 оны хичээлийн жилд 90 багш, 40 гаруй ажилтан албан хаагч, 2238 суралцагчтай байна.

Ковид-19 Цар тахлын үед сургалтыг цахим хэлбэрээр явуулах зорилгоор багш нарын хүчээр Сургалт, удирдлагын цахим системийг боловсруулан нэвтрүүлж, нийт багш, суралцагчдын хичээл цахим талбарт явагдсан байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээний хэрэгжилтийн 92.1 хувь,  хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.5  хувийн биелэлттэй, 3.4 хувь буюу 131,166.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн

дүгнэхэд ур чадварын тэмцээний хураамжийн төлбөрт 2,500.0 мянган төгрөгийг "Түншлэл инновац хөгжил холбоо" төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн тухай хууль, тухайн жилийн баталсан болон тодотгосон төсвийн хуваарь, Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэрт нийцүүлэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд тавих хяналт сул байгааг цаашид анхаарах шаардлагатай.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд оруулбал зохих 149 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроосон, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

> <u>Шийдвэрлэсэн нь: </u>Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 203,653.1 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илрүүлснээс 136,603.9 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 67,049.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад сургалтын материал худалдан авалттай холбоотой төлбөрийн баримт бүрдүүлэлттэй 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг бүрэн ханган биелүүлж, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, албан бичгээр хүргүүлсэн байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 2 | 402,950.0 | 1 | 402,950.0 | 1 | - | 88.0 |
| Зөвлөмж | 2 | 93.2 | 2 | 93.2 | - | - | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **403,043.2** | **3** | **403,043.2** | **1** | **-** | **94.0** |

Өмнөх аудитаар төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, түрээсийн орлогын төлбөрийг дутуу шилжүүлсэн, үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зэрэг асуудлаар өгсөн зөвлөмж албан шаардлагыг хэрэгжүүлсэн, шилэн дансны мэдээлэл хоцроосон албан шаардлагыг 88.0 хувьтай биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төлөвлөлт, зарцуулалт болон дотоод аудитын ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайланг нягтлан үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 539,700.6 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 522,450.2 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 16,869.3 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 381.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 17,250.4 мянган төгрөг нь тогтоосон материаллаг байдал түвшнээс 16,951.5 мянган төгрөгөөр бага тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлан нь өмнөх оны аудитлагдсан санхүүгийн үр дүнгийн тайлангаас 261,225.1 мянган төгрөгөөр зөрүүтэй;
- Өмнөх оны цэвэр хөрөнгийн тайлан нь өмнөх оны аудитлагдсан цэвэр хөрөнгийн тайлангаас 261,225.1 мянган төгрөгөөр зөрүүтэй.

### 4.2 Албан шаардлага

1. Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага зардлын төсвийн ангиллаас 1,922.8 мянган төгрөгөөр биеийн тамирын хувцас худалдан авч зардлыг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэх заалттай нийцэхгүй байна.

> Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

2. Тайлант хугацаанд захиргаа, үйлчилгээний ажилтнуудын илүү цагийг журамд заасан хэмжээг зөрчиж, 2,229.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.3-т “ Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3. Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй 12,716.9 мянган төгрөгийн цахим сургалтын ухаалаг дэлгэц, цахим чиглүүлэгчийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэх заалтуудтай нийцээгүй, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагч төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, хэмнэж ажиллах, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-ыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

**4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын бүргэлтэй холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Шатахууны тайланг үндсэн баримт, жолоочийн тооцооны хуудастай тулган шалгаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан норм, нормативын дагуу километр тутмын давтан тооцоолол хийхэд шатахууныг 381.1 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөж, шатахуун зарцуулалтыг норм, нормативын дагуу хийж, шатахууны зардлыг хэмнэх, алдаа зөрчлийг давтан гаргахүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар** | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШЗ | Өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлан нь өмнөх оны аудитлагдсан санхүүгийн үр дүнгийн тайлангаас зөрүүтэй байна. | Санхүүгийн үр дүнгийн тайланд залруулга хийсэн | 1 | 261,225.1 | 1 | 261,225.1 | | | | | | | | |
| 2 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШЗ | Өмнөх оны цэвэр хөрөнгийн тайлан нь өмнөх оны аудитлагдсан цэвэр хөрөнгийн тайлангаас зөрүүтэй байна. | Өмчийн өөрчлөлтийн тайланд залруулга хийсэн | 1 | 261,225.1 | 1 | 261,225.1 | | | | | | | | |
| 3 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШЗ | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага зардлын төсвийн ангиллаас биеийн тамирын хувцас худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар гаргасан. | Төсвийн зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх албан шаардлага | 1 | 1,922.8 | | | | | 1 | 1,922.8 | | | | |
| 4 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШЗ | Тайлант хугацаанд захиргаа, үйлчилгээний ажилтнуудын илүү цагийг журамд заасан хэмжээг зөрчиж, илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосон байна. | Илүү цагийн тооцооллыг хийхдээ журамд заасны дагуу хийж байх | 1 | 2,229.6 | | | | | 1 | 2,229.6 | | | | |
| 5 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШЗ | Дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй цахим сургалтын ухаалаг дэлгэц, цахим чиглүүлэгчийг төсвийн хөрөнгөөр худалдан | Төсвийн тухай хуульд заасны дагуу батлагдсан төсөв хөтөлбөрийн хүрээнд төсвийн зарцуулалтыг хийж байх | 1 | 12,716.9 | | | | | 1 | 12,716.9 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | авсан байна. | | | | | | | | | | | | | |
| 6 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШ3 | Шатахууны тайланг үндсэн баримт, жолоочийн тооцооны хуудастай тулган шалгаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан норм, нормативын дагуу километр тутмын давтан тооцоолол хийхэд шатахууныг илүү зарцуулсан байна. | Шатахууны зарцуулалтыг батлагдсан норм, нормативаас хэтрүүлэхгүй байх | 1 | 381.1 | | | | | | | | | 1 | 381.1 |
| **Дүн** | | | | | **6** | **539,700.6** | **2** | **522,450.2** | | | **3** | **16,869.3** | | | **1** | **381.1** |
| **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | ҮУПК | АХГ- 2022 /240 / НА – СТА-ТШ3 | Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 139 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 8 мэдээлэл байна. | Шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулж байх, ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага | 1 | - | | | | | 1 | - | 1 | - | | |
| **Дүн** | | | | | **1** | **-** | | | | | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | | | | | **7** | **539,700.6** | **2** | **522,450.2** | | | **4** | **16,869.3** | **1** | **-** | **1** | **381.1** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 16/АО/50058 Улаанбаатар хот
АХГ-2022/240/АА-СТА-ТИ43

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд оруулбал зохих 149 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроон, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 *"Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"*, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил гаргасан, нягтлан бодогч Б.Хонгорзулд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн захирал Д.Буяндэлгэр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.МӨНХБАЯР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

001080121

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 15/А0150058
АХГ-2022/240/НА-СТА-723 Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага зардлын төсвийн ангиллаас 1,922,850.00 төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүй 12,716,900.00 төгрөгийн цахим сургалтын ухаалаг дэлгэц, цахим чиглүүлэгчийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16 дугаар зүйлийн 16.5.2 "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, дээд шатны захирагчийн шийдвэргүй худалдан авалт хийсэн зэрэг зөрчлүүдийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн захирал Д.Буяндэлгэр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

АЗУРЕ ХҮЛИЙГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ .МӨНХБАЯР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\20220225 Auditin 2 Gazar-27.Docx

001080112

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 14/АО/5 0058 Улаанбаатар хот
АХГ-2020/ ... НА-СТА-ТҮ-3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2021 санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд захиргаа, үйлчилгээний ажилтнуудын илүү цагийг журамд заасан хэмжээг зөрчиж, 2,229,641.46 төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3 " Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т заасанаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Захиргаа, үйлчилгээний ажилтны илүү цагийг журамд заасанаас өндрөөр тооцож, нэмэгдэл олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн захирал Д.Буяндэлгэр, нягтлан бодогч Б.Хонгорзул нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.СЭРЖМЯДАГ

АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Г.МӨНХБАЯР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210*

001080103